



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/85

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, 42.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. "Хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих арга хэмжээ"-ний зардлаас 3 дугаар цэцэрлэг болон Соёлын төвд нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 5,130,000 (таван сая нэг зуун гучин мянга) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Арга хэмжээний төсвийн дагуу 5,130,000 (таван сая нэг зуун гучин мянга) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн зардлаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг Нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

3. Худалдан авах тоног төхөөрөмжийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

4. Арга хэмжээний төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг чанартай удирдан зохион байгуулж, тайлагнан ажиллахыг Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д, хөрөнгө ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч (Б.Даваадолгор), Соёлын төвийн дарга (Л.Түмэнцэцэг) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА П.ГАНЧИМЭГ





Сумын Засаг даргын  
2023 оны 05-р сарын 30-ны өдрийн  
1185 дугаар захирамжийн хавсралт

СОСЛЫН ТӨВ, 3-Р ЦЭЦЭРЛЭГТ ШААРДАЛГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН  
ТӨСӨВ

№	Нэр, төрөл	Хүчин чадал	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Дрож	мм	20	1.800.000	1.800.000
2	Дуу өсгөгч	ш	1	650.000	650.000
3	Шарах шүүгээ	ш	1	2.680.000	2.680.000
<b>Нийт үнэ</b>					<b>5.130.000</b>

ТӨСӨВ ГАРГАСАН:

НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН: *sl.* Б.АЛТАНСҮХ